

**Боловсон хүчний нөөц бүрдүүлэлт,
хүний нөөцийн бодлогын ил тод байдал**

“Монголын Төмөр Зам” ТӨХК нь боловсон хүчний нөөц бүрдүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэн ажиллаж байна.

2016-2017 онд боловсон хүчний нөөц бүрдүүлэх үүднээс Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ЗДТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу УБТЗ-ын харьяа “Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв”-д 8 оюутан амжилттай суралцаж, мэргэжил эзэмшлээ.

“Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв” төгсөгчдийн мэргэжлийн мэдээллийг доорх хүснэгтээр харуулав.

“МСҮТ”	
№	Мэргэжил
1	Өргөөний жижүүр
2	Вагон үзэгч
3	Өргөөний жижүүр
4	Ачаа вагон хүлээлцэгч
5	Вагон үзэгч
6	Дохиолол холбоо
7	Өргөөний жижүүр
8	Туслах машинч

Мөн 2016-2018 оны хичээлийн жилд “Тээврийн дээд сургууль”-д 3 оюутан компанийн нэр дээр суралцаж тус тус төгссөн. Төгсөгчдөөс нэг ажилтныг Төмөртэй өртөөнд ажлын байраар ханган ажиллаж байна.

“Тээврийн дээд сургууль” төгсөгчдийн мэргэжлийн мэдээллийг доорх хүснэгтээр харуулав.

“Тээврийн дээд сургууль”	
№	Мэргэжил
1	Замын аж ахуй
2	Тээврийн менежмент
3	Тээврийн менежмент

Тус компани өөрийн боловсон хүчнийг мэргэшүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд 2 ажилтныг 2017-2018 оны хичээлийн жилд УБТЗ-ын “МСҮТ”-д суралцуулж, төгссөн бөгөөд төгсөгчид Төмөртэй өртөөнд ажиллаж байна.

“Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв” төгсөгчдийн мэргэжлийн мэдээллийг доорх хүснэгтээр харуулав.

“МСҮТ”	
№	Мэргэжил
1	Замын аж ахуй
2	Замын аж ахуй

Цаашид “Монголын Төмөр Зам” ТӨХК нь ажиллах хүчний нөөцийг мэргэшүүлэх, ажлын гүйцэтгэлийг сайжруулах бодлогын хүрээнд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.